



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Бие тамир спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/15/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayard@audit.gov.mn">ankhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 70353717 Цахим хаяг: <a href="mailto:dalaivan.orkhon@gmail.mn">dalaivan.orkhon@gmail.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БТСГ	Биеийн тамир, Спортын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

 <b>БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b>		<b>БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА А.ХАНДДОРЖ ТАНАА</b>
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580		
2022-02-25 № 32		
танай _____	_____ -ны № _____	Т _____
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p><b>Дүгнэлтийн үндэслэл</b></p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p><b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b></p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p> <p><b>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</b></p> <p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p> <p>Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.</p>		
		D:/bichighereg/2022A4toot
		<b>006020651</b>

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>100,450,424.00</b>	<b>84,683,624.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	18,118,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	18,118,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	18,118,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	82,332,424.00	84,683,624.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,738,464.00	6,378,464.00
35110	Тусгай зориулалттай материал	3,960,000.00	3,960,000.00
35130	Эм боох материал	1,778,464.00	2,418,464.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	76,593,960.00	78,305,160.00
35410	Бичиг хэргийн материал	3,205,310.00	8,326,710.00
35420	Аж ахуйн материал	68,499,650.00	64,204,450.00
35450	Барилгын засварын материал	4,889,000.00	5,774,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,399,207,497.46</b>	<b>6,270,395,822.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,399,207,497.46	6,270,395,822.79
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,296,187,497.46	6,159,540,522.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,468,281,188.68	6,468,281,188.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(356,939,462.89)	(475,627,553.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,600,000.00	73,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,279,999.97)	(15,039,999.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,916,219.00	118,871,279.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,830,749.88)	(81,683,101.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,272,554.38	63,208,254.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,797,305.18)	(38,033,216.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	45,749,561.20	45,749,561.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	240,226.00	240,226.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(64,733.88)	(66,115.20)
39217	Ном	40,000.00	40,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	103,020,000.00	110,855,300.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(337,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	101,670,000.00	109,842,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,499,657,921.46</b>	<b>6,355,079,446.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,000.00</b>	<b>15,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15,000.00	15,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	15,000.00	15,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	15,000.00	15,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	15,000.00	15,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,499,642,921.46</b>	<b>6,355,064,446.79</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,499,642,921.46	6,355,064,446.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,397,448,304.08	3,397,448,304.08
51101	Өмч: - төрийн	1,615,871,536.08	1,615,871,536.08
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,314,169,550.78	2,169,591,076.11
51210	Өмнөх үеийн үр дүн	2,314,169,550.78	2,314,169,550.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	(144,578,474.67)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,025,066.60	788,025,066.60

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> VI=IV+V	<b>6,499,657,921.46</b>	<b>6,355,079,446.79</b>
---	---	-------------------------	-------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>929,008,514.00</b>	<b>802,906,724.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>82,669,314.00</b>	<b>23,972,950.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	82,669,314.00	23,972,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,669,314.00	23,972,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,082,400.00	10,190,150.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	70,586,914.00	13,782,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>846,339,200.00</b>	<b>778,933,774.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	336,552,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	336,552,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,220,000.00	14,844,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,720,000.00	4,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	9,874,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	820,119,200.00	424,876,814.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	820,119,200.00	424,876,814.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	2,660,060.00
133003	Хөрөнгийн	-	2,660,060.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>954,276,470.52</b>	<b>947,363,790.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>954,276,470.52</b>	<b>947,363,790.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	923,636,484.75	931,177,066.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	271,671,631.06	263,330,578.85
210101	Үндсэн цалин	210,154,774.64	259,172,101.85
210102	Нэмэгдэл	53,361,339.42	4,158,477.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,155,517.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,534,406.17	34,419,393.00
210201	Тэтгэврийн даатгал	26,692,469.34	24,395,610.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,256,843.10	2,661,214.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,711,322.52	2,081,991.64
210204	Ажилгүйдлийн даатгал	133,261.76	480,079.70
210205	Эрүүл мэндийн даатгал	4,740,509.45	4,800,496.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	412,751,854.00	422,476,814.00
210301	Гэрэл, цахилгаан	18,404,093.00	17,940,592.00
210302	Түлш, халаалт	378,116,145.00	378,108,700.00
210303	Цэвэр, бохир ус	16,231,616.00	26,427,522.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,047,440.00	13,223,690.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	480,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,679,340.00	2,220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	760,790.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,857,600.00	2,331,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	910,500.00	569,100.00

210408	Бараа материал акалсны зардал	-	6,862,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,830,250.00</b>	<b>1,515,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,025,400.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	124,500.00	-
210604	Урсгал засвар	680,350.00	1,515,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>291,500.00</b>	<b>921,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	291,500.00	921,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,147,874.00</b>	<b>3,199,264.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,147,874.00	3,199,264.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>185,361,529.52</b>	<b>192,091,326.23</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,681,536.00	36,698,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	137,679,993.52	155,393,126.23
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,639,985.77</b>	<b>16,186,724.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,200,000.00</b>	<b>1,065,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,065,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,439,985.77</b>	<b>15,121,724.15</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,439,985.77	15,121,724.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(25,267,956.52)</b>	<b>(144,457,066.23)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>121,408.44</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	121,408.44
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(121,408.44)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(25,267,956.52)</b>	<b>(144,578,474.67)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,397,448,304.08</b>	<b>788,025,066.60</b>	<b>2,314,169,550.78</b>	<b>6,499,642,921.46</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-144,578,474.67	-144,578,474.67
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,397,448,304.08</b>	<b>788,025,066.60</b>	<b>2,169,591,076.11</b>	<b>6,355,064,446.79</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>846,339,200.00</b>	<b>799,583,864.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>10,190,150.00</b>

120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	10,190,150.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	10,190,150.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,190,150.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>846,339,200.00</b>	<b>789,393,714.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	336,552,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	336,552,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,220,000.00	27,964,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,720,000.00	4,970,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	22,994,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	820,119,200.00	424,876,814.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	820,119,200.00	424,876,814.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>832,071,500.00</b>	<b>786,463,864.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>832,071,500.00</b>	<b>786,463,864.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>788,311,514.23</b>	<b>770,267,139.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	271,458,965.06	263,330,578.85
210101	Үндсэн цалин	209,942,108.64	259,172,101.85
210102	Нэмэгдэл	53,361,339.42	4,158,477.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,155,517.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,534,406.17	34,419,393.00
210201	Тэтгэврийн даатгал	26,692,469.34	24,395,610.32
210202	Тэтгэмжийн даатгал	1,256,843.10	2,661,214.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,711,322.52	2,081,991.64
210204	Ажилгүйдлийн даатгал	133,261.76	480,079.70
210205	Эрүүл мэндийн даатгал	4,740,509.45	4,800,496.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	412,751,854.00	422,476,814.00
210301	Гэрэл, цахилгаан	18,404,093.00	17,940,592.00
210302	Түлш, халаалт	378,116,145.00	378,108,700.00
210303	Цэвэр, бохир ус	16,231,616.00	26,427,522.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,565,840.00	7,143,700.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	480,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,679,340.00	2,210,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	915,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,498,250.00	2,815,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	788,250.00	723,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	250,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	989,400.00	2,604,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	289,400.00	204,000.00
210604	Урсгал засвар	700,000.00	2,400,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	291,500.00	921,000.00
210702	Дотоод албан томилолт	291,500.00	921,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,577,324.00	3,530,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,577,324.00	3,530,454.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	47,892,225.00	35,841,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,892,225.00	35,841,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,759,985.77</b>	<b>16,196,724.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,200,000.00	1,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,075,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	15,121,724.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15,121,724.15
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	42,559,985.77	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,559,985.77	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,267,700.00</b>	<b>13,120,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>26,350,000.00</b>	<b>13,120,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,350,000.00</b>	<b>13,120,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	26,350,000.00	13,120,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	13,120,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,350,000.00	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(26,350,000.00)</b>	<b>(13,120,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	771,735,600.03	756,498,139.85
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	771,735,600.03	756,498,139.85
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	770,169,000.03	755,423,139.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	270,552,400.03	263,330,578.85
210101	Үндсэн цалин	270,552,400.03	259,172,101.85
210102	Нэмэгдэл	-	4,158,477.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,224,500.00	34,419,393.00
210201	Тэтгэврийн даатгал	27,602,400.00	24,395,610.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,905,500.00	2,661,214.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,324,400.00	2,081,991.64
210204	Ажилгүйдлийн даатгал	581,100.00	480,079.70
210205	Эрүүл мэндийн даатгал	5,811,100.00	4,800,496.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	432,782,700.00	422,476,814.00
210301	Гэрэл, цахилгаан	26,674,000.00	17,940,592.00
210302	Түлш, халаалт	378,108,700.00	378,108,700.00
210303	Цэвэр, бохир ус	28,000,000.00	26,427,522.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,143,700.00	7,143,700.00
210401	Бичиг хэрэг	480,000.00	480,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,210,000.00	2,210,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915,000.00	915,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,815,100.00	2,815,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	723,600.00	723,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,604,200.00	2,604,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	204,000.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	2,400,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	921,000.00	921,000.00
210702	Дотоод албан томилолт	921,000.00	921,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,533,400.00	3,530,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,533,400.00	3,530,454.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,407,100.00	20,997,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,407,100.00	20,997,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,566,600.00	1,075,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,566,600.00	1,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,566,600.00	1,075,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	771,429,714.00	771,619,864.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	336,552,900.00	336,552,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	336,552,900.00	336,552,900.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	424,876,814.00	424,876,814.00
132001	Орон нутгийн төсвөөс	424,876,814.00	424,876,814.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	10,000,000.00	10,190,150.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,190,150.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30	30
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	21	21

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>27,964,000</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,844,000</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	14,844,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,844,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,844,000
22	Хөрөнгийн зардал	13,120,000
	Дотоод эх үүсвэр	13,120,000
222001	Тоног төхөөрөмж	13,120,000
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>27,964,000</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>27,964,000</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,970,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,994,000

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, Спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Биеийн тамир, Спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ... дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Бие тамир спортын газрын 2021 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, ТАХ-ийн сургалт нийгмийн баталгааны хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга болон аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хавсралт 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн биелэлт, Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ гэсэн үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд агентлагийн жилийн үйл ажиллагааны үнэлгээний нэгдсэн дүнгээр 4.0 оноо буюу 91.0 хувьтай дүгнэсэн байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй, арга хэмжээ зохион байгуулаагаагүй үнэлэх боломжгүй 3 арга хэмжээ. Үүнд:

- Хөл бөмбөг 2022 онд зураг төсөв нь хийгдэж, 2023 онд ашиглалтад орно.
- “Булган марафон 2021” бүх нийтийн гүйлтийн арга хэмжээ ковид цар тахлын улмаас зохион байгуулаагаагүй
- Өвлийн мөсөн гулгуурын талбайг Булган Мээж ТӨК ярилцан усны асуудлыг шийдсэн боловч цаг агаарын дулаарлын байдлаас шалтгаалан саатаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, Спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 435,182.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,527.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,569.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Биеийн тамир, Спортын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,578.5 мянган төгрөгөөр буюу 2.22 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	82,332.42	84,683.62	2,351.20
Үндсэн хөрөнгө	6,399,207.49	6,270,395.82	(128,811.67)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,499,657.92</b>	<b>6,355,079.44</b>	<b>(144,578.47)</b>
Өр төлбөр	15.00	15.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,499,642.92	6,355,064.44	(144,578.47)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,499,657.92</b>	<b>6,355,079.44</b>	<b>(144,578.47)</b>

Бараа материалын данс 84,683.62 мянган төгрөг болж 2,351.2 мянган төгрөгөөр өссөн нь бага үнэтэй түргэн элэгдэх материал болон тусгай зориулалтын материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 21,521.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 12,308.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Мөн аж ахуйн материалаас 6,862.2 мянган төгрөг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,270,395.82 мянган төгрөг болж 128,811.67 мянган төгрөгөөр буурсан 2021 онд Ухаалаг самбар төхөөрөмжүүдийг 13,120.0 төгрөгөөр нэмэгдэж, Компьютер 5,410.06 төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авч, 8,172.8 төгрөгөөр газар шинээр үндсэн хөрөнгөд орлогодон аваад хөрөнгө 639.30 мянган төгрөгийн хөрөнгө акталсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,355,064.44 мянган төгрөг болж 144,578.47 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Бие тамир спортын газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 944,607.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 944,607.1 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 136,300.6 мянган төгрөгөөр бууруулан 808,306.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 36,876.8 мянган төгрөгөөр бууруулж, 771,429.7 мянган төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 336,552.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 424,876.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 10,190.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 756,613.8 мянган төгрөгийг зарцуулж, 15,121.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 756,613.8 мянган төгрөг буюу 98.03 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 7,221.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4,805.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,305.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймгаас санхүүжилтээр 4,970.0 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 22,994.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна. Үүнээс 13,120.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авсан, 14,844.0 мянган төгрөгийг тэмцээн уралдааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 34 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэсэн заалтын дагуу дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан акталж устгах заасантай нийцэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бие тамир спортын газар нь 2021 онд нийт 761.429.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 761,429.7 мянган төгрөгийн 148 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аудитын явцад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 9,090.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй болно. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 180.3 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 672.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,292.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт 1.Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	672.5	1	672.5	-	-	
Албан шаардлага	-	-	-	-	-	-	
Зөвлөмж	2	1,292.0	2	1,292.0	-	-	
Нийт дүн	3	1,964.5	3	1,964.5	-	-	

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,138.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 180.3 мянган акт, 957.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа байхгүй болно.

### 4.2 Акт

#### 1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 180.3 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заалтыг зөрчсөн тул акт хүргүүлэв.

### 4.3 Албан шаардлага

Тайлант онд албан шаардлага байхгүй.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

#### 1.2. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 34 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49 Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай " гэсэн заалтын дагуу дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан акталж устгах.

#### Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг үр дүнтэй хийж хөрөнгийн жагсаалтыг гарган дээш мэдээлэх.

## **2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Зардлын ангиллыг шилжүүлэн шуудан холбооны зардлаас бичиг хэргийн зардалд, хог хаягдлын зардлаас эм бэлдмэлд нийт 637.7 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190-р тушаалын дагуу Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын дагуу тайлагнаж бүртгэх, мөн төсвийн тухай хуулийн 22.6.7.төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах гэсэн заалтуудын дагуу зардлыг зориулалтаар нь зөв ангилан бүртгэх

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Холбогдох хууль дүрмийг баримтлан ажиллах.

## **3. Зардлын данстай холбоотой асуудал**

### **3.1. Илрүүлэлт:**

Ажилчдын цалинг тооцохдоо ХХОАТ-ийн хөнгөлөлтийг 65.0 мянган төгрөгөөр дутуу, 8.0 мянган төгрөг дутуу тооцоолж тайлагнасан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ: 0-6 сая хүртэл 240.0 мянган төгрөг, 6-12 сая хүртэл 216 мянган төгрөг хөнгөлнө гэсэн заалтын дагуу хөнгөлөлтийг үнэн төв тооцоолох

### **Өгсөн зөвлөмж:**

Холбогдох хууль дүрмийг баримтлан ажиллах.

## **4. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал**

### **4.1. Илрүүлэлт:**

Шилэн дансанд 1 мэдээлэл хугацаа хоцроож, 9 090.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэц худалдан авсан гүйлгээг шивж оруулаагүй байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтын дагуу хугацаанд нь мэдээлж байх

### **4.2. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

## **5. Зардлын данстай холбоотой асуудал**

### **5.1. Илрүүлэлт:**

Групп тогтоолгосон ажилтны амралтын мөнгийг тооцохдоо групптэй хүнд нэмж олгох хоногийг тооцоогүй 262.8 мянган төгрөгийн амралтын мөнгийг дутуу бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтаар амралтын хоногийг нэмж биеэр амрааж амралтын мөнгийг тооцож олгох

### **5.2. Өгсөн зөвлөмж:**

Хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/


Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бие тамир спортын газар	6	1,138.0	-	-	1	180.3	-	-	5	957.7
Нийт дүн		6	1,138.0	-	-	1	180.3	-	-	5	957.7

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

**ХЯНАСАН:**

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :



Д.МЯГМАРСҮРЭН

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР